# ГАРЧИГ


НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА....3

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл....3

1.2 Дэд бүтэц....5

1.2.1 Зам шугам сүлжээ, харилцаа холбоо....5

1.2.2 Цахилгаан хангамж....5

1.2.3 Усан хангамж ба ус ашиглалт....5

1.3 Төслийн хүчин чадал, техник технологи....5

1.3.1 Технологийн дараалал....6

1.3.2 Түүхий эд хүлээн авах бэлтгэх:....7

1.3.3 Бүтээгдэхүүн хадгалалт, тээвэрлэлт, эргүүлэн таталт....7

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ....9

2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авсан арга хэмжээ....10

2.1.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ....10

2.1.2 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ....12

2.1.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ....12

2.1.4 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ....13

2.1.5 Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөлөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ....15

2.1.6 Нөхөн сэргээлт, “Тэр бум мод” хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ....15

2.1.7 Хог хаягдлын менежмент, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ....16

2.1.8 Түүх, соёлын дурсгалт зүйлсэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ....16

2.1.9 Осол, эрсдэлийн төлөвлөгөө ба ХАБЭА-н чиглэлээр гүйцэтгэсэн ажлууд....17

2.1.10 Удирдлага, зохин байгуулалт, оролцогч талуудад тайлагнах чиглэлээр....18

2.1.11 Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөө ба хэрэгжилт....19

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл ........ 3
Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын зарцуулалт ........ 9
Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт ........ 18
Хүснэгт 4. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт ........ 22

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил ........ 3
Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байдал ........ 4
Зураг 3. Үйлдвэрийн тоног төхөөрөмж, дотоод зохион байгуулалт ........ 6
Зураг 4. Бэлэн болсон бүтээгдэхүүн ........ 8
Зураг 5. Үйлдвэрийн гадна талбайг хатуу хучилттай болгосон байдал ........ 12

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

“Өлзийт тал“ ХХК нь 2017-11-29 өдөр гадаад худалдаа, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр байгуулагдсан ба өөрийн хөрөнгө оруулалтаар 2018 онд нийслэлийн Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэр буюу Үйлдвэрийн баруун бүс. ТЭЦ-4 гудамж, 1-116 тоот хаяг /иргэн Д.Ганхуягийн 1681910144 дугаартай газрыг түрээслэн/-т контор, үйлчилгээ, үйлдвэрлэлийн зориулалттай 1815 $м^2$ талбайтай, 2 давхар барилга барьж ашиглалтанд оруулан, үл хөдлөх эд хөрөнгийн 000632291 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээ бүхий Ү-2205067179 дугаарын хөрөнгийн бүртгэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Улмаар, 2019 оны 12 сард үйлдвэрлэлийн цехийн байр, агуулахын зориулалтаар ашиглах 877 $м^2$, ажиллагсдын амрах байр, хоолны газрын зориулалтаар нийт 174 $м^2$ өргөтгөлийн барилгыг өргөтгөлөөр барьж, эд хөрөнгийн улсын бүртгэлийн Ү-2205071984, Ү-2205071985 дугаартай өмчлөлийн гэрчилгээ авсан.

*Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл*

| Төслийн нэр: | “Мах боловсруулах үйлдвэр” |
|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгч: | “Өлзийт Тал” ХХК |
| Төслийн байршил: | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Дунд гол, Үйлдвэрийн баруун бүс гудамж ТЭЦ-4, 1-116 тоотод байрлана. |
| Төслийн талбай, $м^2$ | 4263 |
| Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн дугаар, | 9019086072 |
| Регистрийн дугаар: | 6253326 |
| Төсөл хэрэгжүүлэгчийн утасны дугаар: | 90118000 |




*Зураг 2. Төслийн талбайн байршил*



*Зураг 3. Төслийн талбайн ерөнхий байдал*

Үйлдвэрийн барилга-угсралтын ажил нь “Арч пойнт” ХХК зэрэг мэргэжлийн байгууллагын зураг төслийн дагуу хийгдсэн, гадна дулаан, цэвэр усан хангамжийн системийн угсралтыг сорилоор шалгасан актыг 2017-11-08 өдөр авсан.

Мах боловсруулах үйлдвэрийн байр нь мах шулах, ангилах, чанах, боловсруулах, савлах, хадгалах цехүүдтэй ба бүтээгдэхүүн хадгалах зориулалтын гүн (-36$^{0}$С) хөлдөөх 95м$^{3}$ ба 83.4м$^{3}$ ашигтай талбай бүхий 2ш болон хөргөлттэй бүтээгдэхүүн (-18$^{0}$С)-ий 255м$^{3}$ талбайтай 2ш, 246м$^{3}$ талбайтай 1ш агуулахыг тус тус ашиглана.

Бүтээгдэхүүнийг чанах, утах, хатаах, савлах зориулалтын тоног төхөөрөмжийг технологийн уураар халаах болон үйлдвэрлэлийн байрны дулаан хангамжийн зориулалтаар “ТЭЦ-4” ТӨХК-ийн уурын шугаманд холбогдсон ба технологийн эрчим хүчний уураар хангах, ашиглалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах гэрээг тус компанитай байгуулан ажилладаг.

Бэлтгэсэн махыг УБ хот дахь өөрийн үйлдвэрийн хөргүүртэй агуулахад 147.5тн /гулуузаар/ хадгалахаас гадна Налайх дүүрэг дэх “Хосхийморь” ХХК-ийн хөргүүртэй зоориnд 100тн мах хадгална. Компаний хэмжээнд, үхрийн 5250ш гулууз буюу нийт 181.25тн мах бэлтгэхээр 2024 онд төлөвлөсөн.

## 1.2 Дэд бүтэц

### 1.2.1 Зам, шугам сүлжээ, харилцаа холбоо

Төслийн талбай нь үйлдвэрийн баруун бүсийн төв замын дагуу буюу ТЭЦ-4 үйлдвэрийн урд талд байрлах ба харилцаа холбооны бүхий л сүлжээг ашиглах бүрэн боломжтой газар болно.

### 1.2.2 Цахилгаан хангамж

Төвийн цахилгаан сүлжээнд холбогдсон.

### 1.2.3 Усан хангамж ба ус ашиглалт

Үйлдвэр нь цэвэр болон бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон, технологийн хэрэгцээний уур болон дулааныг “ТЭЦ-4”ТӨХК-иас авдаг бол унд ахуйн хэрэгцээний усыг гүний худгаас хангана. Нийслэлийн байгаль орчны газрын 2019-05-08 өдрийн 296 тоот зөвшөөрлөөр “Байдраг консалтинг” ХХК-ий гаргасан, 50м гүнтэй, 3л/с ундарга бүхий, химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натри-калийн бүлгийн 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг буюу ялимгүй эрдэсжилттэй, маш зөөлөн устай худаг болно.

Түүхий эд, бүтээгдэхүүнийг 82$^0$С-ээс доошгүй хэмтэй, ундны усны шаардлага /MNS900:2005/ хангасан даралтат халуун усаар шүршиж, угаах ба усны температурыг тогтмол хэмжиж, бүртгэл хөтлөн, лабораторийн шинжилгээнд хамруулдаг байна.

Төслийн явцад гарах бохир усыг Хорих 461-р ангийн шугамд нийлүүлэх ба Ус сувгийн удирдах газартай 2017 оноос хойш гэрээ байгуулан ажиллаж ирснээс байнгын үйлчлүүлэгчээр бүртгэгдэн, жил бүрийн гэрээ автоматаар сунгагдаж байх горимд шилжжээ.

## 1.3 Төслийн хүчин чадал, техник технологи

Мах боловсруулах үйлдвэр нь 1815 м$^2$ талбайтай, хоногт 8-10 тн, жилд 3600тн мах боловсруулах хүчин чадалтай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй, өдрийн 8 цаг, ажлын 5 хоног, жилийн 12 сард үйл ажиллагаа явуулна.

Үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл нь хүнсний зориулалтын, зэвэрдэггүй материалаар хийгдсэн хутга, бусад тоног төхөөрөмжтэй, зориулалтын вандан тавиураар хангагдсан, жин хэмжүүрийг улсын баталгаажилтанд хамруулсан байх ба мэргэжлийн болон мэргэшсэн ажиллагсад нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан байх бөгөөд бүх ажилчид хөдөлмөр хамгаалльн хувцастай байна. Түүхий эдийг бэлтгэн нийлүүлэлтийн гэрээний дагуу мал эмнэлэг ариун цэвэр гарал үүслийн гэрчилгээ баталгаажилттай хүлээн авна.

Үйлдвэр нь нядалгаа хийгдсэний дараа боловсруулахад бэлэн болсон хонь, үхэр, ямааны мах хүлээн авна. Үндсэн түүхий эд болох, халуун усанд зумлаж, шийрийг салган хөлдөөсөн, сүүлгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан хонь, ямааны махыг “Эрдэнэ хүнс” ХХК /МХЕГ-ын даргын 2018 оны А/03 дугаар тушаалаар “АА” зэрэглэлийн итгэмжлэлтэй үйлдвэр /-иас гэрээний дагуу авдаг.



*Зураг 4. Үйлдвэрийн тоног төхөөрөмж, дотоод зохийн байгуулалт*

### 1.3.1 Технологийн дараалал

Гарал үүслийн бичигтэй, мал эмнэлгийн үзлэг шинжилгээ хийсэн мах, түүхий эдийг хүлээн авч, бүртгэл хөтөлнө Сав баглаа, боодлыг тусгай зөвшөөрөлтэй байгууллагаас гэрээгээр хүлээн авах ба мэргэжлийн хяналтын газрын төв лабораторын эрүүл ахуйн сорилын шинжилгээний бичгийг хавсарган хүлээн авч, бүртгэл хөтөлнө. Бусад амтлагч, дагалдах түүхий эд материалыг итгэмжлэгдсэн лабораторийн хүнсний эрүүл ахуй ариун цэврийн сорилын дүнгийн хамт хүлээн авч, бүртгэл хөтөлнө.

Гэсгээх өрөөний температур 0-5$^{0}$C дулаан байх ба агаарын урсгалд жигд байхаар тоноглогдсон байх ба температурыг тогтмол хэмжин, бүртгэл хөтөлнө. Үйлдвэрлэгдэж буй

бүтээгдэхүүн нь тус бүрдээ батлагдсан технологийн заавартай, эрсдэл үүсгэх горимуудыг тусгасан заавар зааварчилгаатай байна.

### 1.3.2 Түүхий эд хүлээн авах бэлтгэх:

- Гэсгээх, эвдэх, шулах, жижиглэх
- Ангилан сортлох
- Сойх /2-4 ц/
- Чанах 130-150$^0$С
- Хөргөх температур 5$^0$С
- Савлах хадгалах
- Бэлэн бүтээгдэхүүн гарах
- Шулалгаа, ангилгаа нь технологийн зааварчилгаатай ба өрөөний температурыг хэмжиж бүртгэл хөтөлдөг.
- Дулааны боловсруулалт нь өрөө болон цэвэрлэгээ ариутгалын график бүртгэлтэй, ус ба махны гүний температурыг хэмжиж, бүртгэл хөтөлнө.
- Стандартын дагуу загсаасан махыг жижиглэн вакум савлагаанд савлаж, бүртгэлжүүлнэ.
- Савлагдсан бүтээгдэхүүнийг автоклавт оруулан +120 хэмийн ариутгал хийн гаргадаг.
- Ариутгал хийгдэж, савлагдсан бүтээгдэхүүнийг хатаах шугам, машинд оруулан хатааж +20 хэмийн температурт 1 минут цаасан хайрцагт савладаг.

### 1.3.3 Бүтээгдэхүүн хадгалалт, тээвэрлэлт, эргүүлэн таталт

- Савлагдсан бүтээгдэхүүнийг -18 хэмийн бэлэн бүтээгдэхүүний агуулахад хийж, агуулахын температурын бүртгэл хөтөлдөг.
- Бүтээгдэхүүнийг зориулалтын хөргөлттэй тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг
- Зах зээлд гаргасан бэлэн бүтээгдэхүүнд тээвэрлэлт хүргэлтийн хяналтын бүртгэл хөтлөн, хадгалалтын хугацаа дууссан, сав баглаа боодлын гэмтэлтэй бүтээгдэхүүнүүдийг татан авч устгал хийн бүртгэл хөтөлдөг.
- Бүтээгдэхүүний хаяг шошго, аюулгүй байдлын баталгаажуулалт
- Бэлэн бүтээгдэхүүнд Монгол улсад мөрдөгдөж байгаа хаяг шошгоны стандартын дагуу бүтээгдэхүүн тус бүрт хаяг шошго захиалан хийлгэдэг. /хадгалах хугацаа, хэрэглэх заавар, тэжээллэг чанар, үйлдвэрлэсэн огноо,үйлдвэрийн хаяг/ зэрэг орно.
- Шулалгаа, ангилгаа нь технологийн зааварчилгаатай ба өрөөний температурыг хэмжиж бүртгэл хөтөлдөг.
- Дулаан боловсруулалт нь өрөө болон цэвэрлэгээ ариутгалын графикбүртгэлтэй ба дулаан боловсруулалтын бүртгэл хөтөлж, ус ба махны гүний температурыг хэмжиж бүртгэл хөтөлдөг.
- Стандартын дагуу загсаасан махыг жижиглэн вакум савлагаанд савлаж бүртгэл хөтөлдөг.
- Савлагдсан бүтээгдэхүүнийг автоклавт оруулан +120 хэмийн ариутгал хийн

гаргадаг.

- Ариутгал хийгдэж, савлагдсан бүтээгдэхүүнийг хатаах шугам, машинд оруулан хатааж+20 хэмийн температурт 1минут цаасан хайрцагт савладаг.
- Бүтээгдэхүүн хадгалалт, тээвэрлэлт, эргүүлэн таталт
- Савлагдсан бүтээгдэхүүнийг -18 хэмийн бэлэн бүтээгдэхүүний агуулахад хийж, агуулахын температурын бүртгэл хөтөлдөг.
- Бүтээгдэхүүнийг зориулалтын хөргөлттэй тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг
- Зах зээлд гаргасан бэлэн бүтээгдэхүүнд тээвэрлэлт хүргэлтийн хяналтын бүртгэл хөтлөн, хадгалалтын хугацаа дууссан, сав баглаа боодлын гэмтэлтэй бүтээгдэхүүнүүдийг татан авч устгал хийн бүртгэл хөтөлдөг.
- Бүтээгдэхүүний хаяг шошго, аюулгүй байдлын баталгаажуулалт
- Бэлэн бүтээгдэхүүнд Монгол улсад мөрдөгдөж байгаа хаяг шошгоны стандартын дагуу бүтээгдэхүүн тус бүрт хаяг шошго захиалан хийлгэдэг./ хадгалах хугацаа, хэрэглэх заавар, тэжээллэг чанар, үйлдвэрлэсэн огноо,үйлдвэрийн хаяг/ зэрэг орно.

Боловсруулалт хийсэн мах, махан бүтээгдхүүнүүд нь:

1. Хатаасан борц: 250гр, 300гр, 500гр ,1кг, 5кг
2. Дулааны аргаар боловсруулсан үхрийн мах: 2.5кг, 5кг
3. Дулааны аргаар боловсруулсан ямааны мах: 500гр, 2,5кг, 5кг
4. Дулааны аргаар боловсруулсан хониний мах: 500гр, 2,5кг, 5кг
5. Дулааны аргаар боловсруулсан үхрийн бөөрөнхий мах: 500гр,   2,5кг, 5кг




*Зураг 5. Бэлэн болсон бүтээгдэхүүн*

## ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Төслийн хэрэгжүүлэх явцад байгаль орчин, экологийн чиглэлээр дагаж мөрдөх Монгол улсын хууль тогтоомж, стандарт, дүрэм журмуудыг баримтлан ажиллахаас гадна тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгдсөн арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ААНБ, иргэн бүрийн үүрэг юм. Өөрөөр хэлбэл, энэхүү төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх замаар төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, багасгах, арилгах үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр 6 төрлийн 30 арга хэмжээ, байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нийт 7 ажил тус тус тусгаснаас тайлант хугацаанд 6 төрлийн 27 арга хэмжээг гүйцэтгэж, нийт 3.1 сая төгрөгийн зардал гаргаж, төлөвлөгөөний биелэлт 90% үзүүлэлттэй гарав. Үүнд:

*Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын зарцуулалт*

| Гүйцэтгэх ажлууд | Мөнгөн дүн, төгрөг | |
|---|---|---|
| | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
| Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 1,081,400 | 1,081,400 |
| Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | 1,650,000 | 150,000 |
| Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 277,456 | 277,456 |
| Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 451,000 | 451,000 |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтынтөлөвлөгөө | 1,550,000 | 550,000 |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | 550,000 | 550,000 |
| **Нийт дүн** | **5,559,856.00** | **3,059,856** |

*Тайлбар: Тасалдсан үйл ажиллагаа 3, үүд,*

1. *“Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрийн хашааны гадна тарих ёстой модыг нийслэл хотын цэвэр усны шугамын өргөтгөл, шинэчлэлтэй холбоотойгоор тарьж чадаагүй, үүнд 1.5 сая төгрөг төсөвлөгдсөн байсан.*
2. *Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа болон Байгаль орчны аудит – 2023-2024 онд үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотойгоор уг ажлыг ирэх жилүүдэд хийлгэхээр шийдвэрлэсэн, үүнд 1.0 сая төгрөг төсөвлөсөн /Байгаль орчны аудитыг дотоод зардлаар/байв.*

## 2.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ:

Юуны өмнө, тус үйлдвэрийн өмнө талаар цэвэр усны шугамын өргөтгөл, засварын ажил хийгдэж, орц, гарцыг хааснаас хойш буюу 2024 оны 6-р сараас эхлэн, үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болж, жигдрэхгүй өдийг хүрсэнтэй холбогдуулан, БОМТ-нд тусгасан зарим төрлийн үйл ажиллагаа (Жишээ нь: “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хашааны гадна талд мод тарих, тохижилт хийх, сургалт явуулах, г.м) зогсох буюу тасалдах, улмаар ирэх жилийн төлөвлөгөөнд дахин тусгах зэрэг нөхцөл байдал үүссэнийг тэмдэглэх нь зүйтэй. Нөгөө талаар, компаний баримт бичиг, тусгай зөвшөөрөл болон манхы үнэ ханш өндөр байсан зэргээс шалтгаалж, үйлдвэр 2023 онд ч мөн адил ажиллагаагүй ба одоогоор түр зогсолтын горимд байна.

Хэдий тийм боловч, 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг нөхцөл байдалдаа тааруулан, бүрэн хэмжээгээр гүйцэтгэхийг зорьж ажилласан ба нийт сөрөг нөлөөллийг бууруулах 30 үйл ажиллагаанаас 27 (90%)-г авч хэрэгжүүлээд байна. Зөвхөн БОМТ 2024 төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагаанаас гадна байгаль орчныг хамгаалах, холбогдох стандарт журмуудыг сахих, хэрэгжүүлэх үүднээс тодорхой нэр төрлийн ажлууд хийгдсэнийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрт дурьдаж оруулав.  Үүнд:

### 2.1.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Төслийн зүгээс агаарын чанарт дараахь 4 төрлийн сөрөг нөлөөлөл үзүүлж болох ба үүнд:

- Машин механизмын хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвч элэгдэн, сул шороо үүссэнээр тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх
- Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ууршимтгай органик нэгдлүүд агаарт дэгдэж, тухайн орчны агаар болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх
- Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх
- Хатуу хог хаягдалыг ил задгай хаяснаас агаарын чанарт нөлөөлөх.

Эдгээр сөрөг нөлөөллүүдийг багасгах буюу бууруулах чиглэлээр дараахь арга хэмжээг тус тус тайлант хугацаанд зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

1. Машин механизмын хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвч элэгдэж, тоосжилт нэмэгдэхээс сэргийлж, үйлдвэрийн зам талбайн 95%-г хатуу хучилттай болгож, цардсан.
2. Компаний хэмжээнд 5 автомашин (2 фортер, 1 ачааны машин, 2 суудлын тэрэг) байх ба үйлдвэрийн бусдад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд нь цахилгаан хөдөлгүүртэй тул шатах, тослох материалын ууршилт гэх зүйл гарахгүй.
3. Төслийн талбайд 5 автомашин, 15 тоног төхөөрөмж ажилладаг ба бүх автомашины яндангийн шүүлтүүрийг солиулж 2024 оны 5-7 сард улсын үзлэгт хамруулан “тэнцсэн” үнэлгээ авсан. Авто болон цахилгаан техникийн засвар үйлчилгээг графикт хугацаанд нь тогтмол хийж ирсэн болно.






| Машины дугаар | Татвар | Оношилгоо | Агаарын бохирдол |
|---|---|---|---|
| 4028УНН | 2024он Төлсөн | Тэнцсэн 2025.07.06 | Төлсөн |
| 3047УАН | 93774 | Тэнцсэн 2025.05.18 | Төлсөн |
| 6381УБТ | 229500 | Дууссан | Төлсөн |
| 7812УНК | 2024он төлсөн | Дууссан | Төлсөн |

4. Хатуу хог хаягдлын зөөврийн түр сав 5ш-ийг 2024 онд шинээр худалдан авч, хог хаягдал илүүтэй гарч болох 3 цэгт байрлуулсан ба цаг тухайн үед нь хог хаягдлын түр цэгт төвлөрүүлэх, нийслэлийн тохижилт үйлчилгээний компаниар тээвэрлүүлэх, ил задгай хог хаяхгүй байх зэрэгт тогтмол хяналт тавьж ажилласан /хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр учир маш цэвэр, элдэв төрлийн бохирдолгүй байх үндсэн шаардлагатай/ болно.

### 2.1.2 Газрын гадарга, хөвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөлд:

- Дотоод, гадаад тээвэрлэлтийн журам боловсруулан мөрдөөгүйн улмаас олон салаа зам гарч газрын гадарга их хэмжээгээр эвдэрч болзошгүй.
- Машин техникийн сэлбэг хэрэгсэл, дугуй, шатах тослох материалын хаягдал бохирдолүүсгэж болзошгүй.

Төслийн талбай дахь тээврийн хөдөлгөөний улмаас хөрс, газрын гадарга эвдрэхээс сэргийлэх, нөгөө талаар үйлдвэрлэлийн стандарт шаардлагыг хангах үүднээс хашааны нийт талбайн 95%-ийг цардаж, хатуу хучилттай болгосон.

Төслийн хэрэгцээнд ашиглагдах машин, техникийн засвар үйлчилгээ (дугуй болон тос, масло солих, агаар болон тосны шүүр солих зэрэг)-г автозасварын газруудад тухай тухайн үед нь хийлгэдэг тул аюултай хог хаягдал буюу хөрсний бохирдол үүсэх нөхцөл гардаггүй.

### 2.1.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Төслөөс,

- Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь хатуу хог хаягдал ил задгай хаяснаар хөрс бохирдох
- Шатах тослох материал, техникийн сэлбэг хэрэгсэл болон хатуу хог хаягдлын зохисгүй хадгалалт, зохион байгуултаас хөрс бохирдох

- Болзошгүй галын аюул, осол аваарийн үед гарах үнсний дэгдэлт, химийн бодисын алдагдлаас хөрс бохирдож болзошгүй
- Үйлдвэрээс гарах бохир ус, хатуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах үйл ажиллагаа зохих журмын дагуу хийгдээгүйгээс орчны хөрс бохирдох нөхцөлтэй
- Технологийн горимыг зөрчих, ажиллагсдын хайнга үйл ажиллагааны улмаас орчны хөрсөнд бохирдол үүсэх

Төслийн талбайд хог хаягдал хаях, тээврийн хэрэгслээс шатах, тослох материал асгарах, гоожих, хатуу шингэн хаягдлыг цаг хугацаанд авахуулж байхад тогтмол хяналт, шаардлага тавьж ажилладаг ба технологийн горимыг чанд мөрдөж ирсэн. Хөрсөн бүрхэвч эвдрэх, тээврийн хэрэгслийн шатах, тослох материалаар хөрс, ус бохирдохоос сэргийлж, гадна талбайн 95 орчим хувийг хатуу хучилттай болгосон.



*Зураг 6. Үйлдвэрийн гадна талбайг хатуу хучилттай болгосон байдал*

Түүнчлэн, “Дотоод аудит, дотоод хяналт хэрэгжүүлэх журам”-ыг Гүйцэтгэх захирал А.Баасаннямаар батлуулан, төслийн талбайн дотоод хяналтыг тогтмол хийж ажилладаг (Журмыг хавсаргав).

### 2.1.4 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Төслийн зүгээс усан орчинд үзүүлэх болкошгүй сөрөг нөлөөллийг дараахь байдлаар тодорхойлсон ба үүнд:

- Хаягдал бохир ус стандартад заасан хэмжээнээс давах, улмаар сөрөг нөлөөлөл үзүүлэх
- Үйлдвэрээс гарах бохир ус, хатуу хог хаягдлыг цуглуулах, цэвэрлэх, зайлуулах үйл ажиллагаа

зохих журмын дагуу хийгдээгүйгээс газрын доорх ус бохирдох, цэвэрлэх байгууламжийн ажиллагааны горимыг алдагдуулах зэрэг болно.

Үйлдвэрийн зүгээс, усны холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангахад байнга анхаарч ирсэн ба баримт бичгийн иж бүрдлийг хангах хүрээнд, Нийслэлийн БОГ-ын 2024-05-02 өдрийн 2024/40 тоот ус ашиглуулах дүгнэлт авч, БГД-ийн ЗД-ын 2022-04-19 өдрийн 46 тоот ус ашиглах гэрээг тус тус байгуулан ажиллалаа (Гэрээг хавсаргав).

Гүний худагт 000631 дугаарын усны тоолуурыг Стандарт хэмжил зүйн газрын 00765112 тоот баталгаажуулалтын гэрчилгээний дагуу суурилуулан ашиглаж байна. Гүний худаг нь үзель дотор байрлах тул бохирдох эрсдэл маш бага, эрүүл ахуйн бүс тогтоож, тэмдэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгээд байна.



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
ЦАХИЛГААН ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ 00765112

.............................................................-д
(эзэмшигчийн нэр)
ашиглаж байгаа DTS3 загварын 3
фазын № 1000631 -ын
механик, цахилгаан-механик, электрон тоолуурыг № 010 лацаар
(доогуур зурах)
битүүмжилж 2025 оны 07 -р сарын 19 -ны өдөр
хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.
Шалгалтын дээд хязгаар заалт: 00000.3 кВт/ц
Лабораторийн тэмдэг
Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг
2021 оны 07 -р сарын 19 -ны өдөр









КАПИТРОН БАНК

Огноо/Date: 2024/10/17 15:08:12

Шилжүүлгийн мэдэгдэл/Transaction report

Журналын №/Journal №: 90569000085441

Системийн огноо/System Date: 2024/10/17 15:08:12

Харилцагчийн дугаар/Customer №: 13217069 Нэр/Name: JINLONG

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт | Дансны дугаар/Account №<br>JINLONG JINLONG | Нэр/Name:<br>MN590030003096049999 | Дүн/Amount:<br>98,700.00 MNT | Ханш/Rate:<br>1.0 |
| / 98,700.00 / | | | | |
| Кт | Банкны дугаар/Bank №:<br>90<br>Дансны дугаар/Account №:<br>100900013092 | Банкны нэр/Bank Name:<br>ТӨРИЙН САН<br>Нэр/Name:<br>БОАЖЯ. Усны газар | Дүн/Amount:<br>98,700.00MNT | Ханш/Rate:<br>0.0 |

Гүйлгээний утга/Transaction description:
6253326 өлзийттал ххк

Харилцагч танд баярлалаа/Thank you to our customers



Улаанбаатар хотын Ус Сувгийн Удирдах Газар

Тооцооны хуудас

Огноо: 2024-10-07

Код: 22093400
Нэр: Өлзийт тал ХХК
Хаяг:
Утас: 96664041,99068196
Факс:
И-мэйл: ulzittal@gmail.com
Банк: Банкгүй
Данс: 0
Регистер: 6253326
Эхний үлдэгдэл: -172.55

Хаяг: БЗД Токиогийн гудамж 5
Утас: ХУД-70172227; СХД-77117707; БГД-77117702; СБД-77117715; БЗД-70157013; ЧД -77117716
И-мэйл: usug@ub.gov.mn

| Д/д | Тоолуурын дугаар | Заалт огноо | Ф | Суурь хураамж | Тоолуурын заалт: Эхний | Эцсийн | Зөрүү | Ус/м3/: Цэвэр | Бохир | Нэгж үнэ/₮/: Цэвэр | Бохир | Усны үнэ/₮/: Цэвэр | Бохир |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1703000080 | 10/02 | 25 | 1800.00 | 29394 | 29636 | 242 | 0 | 242 | 2690 | 2920 | 0.00 | 706,640.00 |
| 2 | | | | | | | | | | | | | |
| ДҮН | | | 1 | 1,800.00 | | | | 0 | 242 | | | 0.00 | 706,640.00 |
| Нийт усны дүн: | | | | | | | | | | | | | 706,640.00 |

НӨАТ 71,705.62
НӨАТ төлөх дүн 717,056.18

Тооцооны хугацааны дараах дүн: 788,761.80
Төлбөл зохих төлбөрийн дүн: 788,589.25
Тооцооны хамрах хугацаа: /2024-09-06/ - /2024-10-07/
Төлбөр төлөх эцсийн хугацаа: 2024-10-14

Ус ашиглалттай холбоотой 3 төрлийн төлбөр хураамж төлдөг ба үүнд: 1/. Ус сувгийн удирдах газартай цэвэр, бохир усны үйлчилгээ, 2/. Цагдан хорих 461-р хаалттай ангитай бохирын шугам ашигласны төлбөр, 3/. Усны нөөц ашигласны төлбөрийг дүүрэгт тус тус төлнө. Ус сувгийн удирдах газартай байгуулсан гэрээний дагуу сар бүр байцаагч ирж, усны тоолуурын заалтаар үйлчилгээ үзүүлсний төлбөр ногдуулдаг бол хорих 461 ангид сар бүр 600 мянган төгрөг (үйлдвэр ажиллаагүй тохиолдолд 300 мянган төг) төлдөг.

Ахуйн хэрэглээний шингэн хаягдлын хувьд, хоногт 1225л, жилд 447.1тн бохир ус /35 хүн/ гарахаар төслийн нарийвчилсан үнэлгээнд тооцсон ба үйлдвэр нь төвийн бохир усны шугамд холбогдсон тул ахуйн болон технологийн бохир усыг системд шууд нийлүүлдэг (Гэрээг хавсаргав).

### 2.1.5 Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөлөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Амьтан болон ургамлын хувьд, дараахь нөлөөллүүд үүсч болзошгүй гэж үзсэн ба үүнд:

- Тоосжилтын улмаас ургамлан нөмрөг доройтох,
- Шингэн хог хаягдлыг ил задгай хаяснаас ургамлан бүрхэвч бохирдож болзошгүй,
- Хатуу хог хаягдлыг ил задгай хаяснаас мөн дулааны улиралд үнэр орж муудах,
- Хөрсөнд үүрлэн амьдрагч жижиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүдийн амьдрах орчин алдагдах.

Үйлдвэрийн гадна талбайн 95-98% орчим нь цардмал буюу бетондсон гадаргатай болсон нь хөрс ба ургамал бүрхэвч талхлагдах, агаар болон хүнсний бүтээгдэхүүн тоос болон бусад зүйлсээр бохирдохоос урьдчилан сэргийлсэн чухал ажил болсон ч энэ нь ногоон байгууламж ба жижиг амьтад /мэрэгч болон шавж зэрэг/-ын хувьд тэдийлэн зохимжтой бус байж болох юм. Гэвч, төслийн талбай нь нэгэнт хүн амын суурьшлын бүс тул жижиг мэрэгч болон шавж, зарим нэр төрлийн шувуудаас бусад ан амьтан байхгүй, нөгөө талаар ТЭЦ-4 станц орчмын үйлдвэржилтийн баруун бүс нь аж ахуйн үйл ажиллагааны нөлөөлөлд эртнээс өртөж, ургамлан бүрхэвч устсан буюу хүчтэй нөлөөлөлд орсон талбай болох тул энэ талын сөрөг нөлөө харьцангүй бага байх талтай.

Иймд, төслийн талбайд малын гаралтай болон бусад төрлийн элдэв хог хаягдал хуримтлуулалгүй, нохой муур, зарим төрлийн шувууд, мэрэгч болон шавж ялаа цуглах, агаарт эвгүй үнэр тархахаас ямагт сэргийлэн ажиллаж ирсэн болно.

Үйлдвэрийн хашаан доторх талбайн 2% орчим буюу 10м$^2$ гаруй талбайг ногоон байгууламжийн зориулалтаар ашиглаж, 10 гаруй мод бут тариад байна. Мөн, хашааны гаднах нүүрэн талын талбайд 2025 оноос мод тарьж, зүлэгжүүлэх ажил хийнэ.

### 2.1.6 Нөхөн сэргээлт, "Тэр бум мод" хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Төслийн талбайн нийт хэмжээ 4263м$^2$, үүнээс үйлдвэрлэлийн байр 2527м$^2$, гаднах цардмал талбай 1500м$^2$ гаруй бөгөөд ногоон байгууламжийн зориулалтаар ашиглаж болох талбайн хэмжээ 10-15м$^2$ орчим болно. Тус талбайд 2024 оны байдлаар 10ш чоны хэл жимсний мод тарлсан ба холбогдох арчилгаа, тордолгоог хийж ирлээ. Мөн, "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд хашааны

гадна талбайд 30-50ш мод тарихаар төлөвлөсөн ч нийслэлийн цэвэр усны шугамын өргөтгөл, шинэчлэлтэй холбоотойгоор хийгдэх боломжгүй болсоноос 2025 оны төлөвлөгөөнд дахин тусгахаар шийдвэрлэсэн.

### 2.1.7 Хог хаягдлын менежмент, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Төслийн хүрээнд гарах хог хаягдлыг технологийн болон ахуй /оффис/-н гэж 2 ангилах ба 2024 оны 6 сараас эхлэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөлгүй болсонтой холбоотойгоор, технологийн хог хаягдал гараагүй, ахуйн буюу оффисийн хог хаягдал бага хэмжээгээр гарч, 2-3 сард нэг удаа, нийслэлийн “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-тай 2024-03-05 өдөр байгуулсан 24/22 тоот гэрээний дагуу тээвэрлэн зайлуулуулж ирсэн (Гэрээг хавсаргав).

Хуурай хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий 5ш зөөврийн савыг 3 цэгт нэмэлтээр байрлуулан өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.




Үйлдвэрлэлийн явцад, өдөрт 10.5кг, жилд 3тн орчим ахуйн хуурай хог хаягдал гарахаар төслийн нарийвчилсан үнэлгээний тайланд тооцсон бол технологийн хуурай хог хаягдал нь зөвхөн малын яс байх (малын гаралтай эвэр, туурай, сэвс зэрэг хаягдал гарахгүй) юм. Төслийн хэмжээнд ямар нэг химийн бодис ашигладаггүй тул технологийн хортой бөгөөд аюултай хог хаягдал гэж гарахгүй, харин үйлдвэрлэлд ашиглагдаж буй машин, техник хэрэгслийн дугуй, аккумлятор, тосны болон агаар шүүгч зэрэг байж болох талтай ч засвар үйлчилгээг авто засварын газруудаар хийлгэдэг тул энэ төрлийн хог хаягдал гардаггүй.

### 2.1.8 Түүх соёлын дурсгалт зүйлсэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Төсөл хэрэгжих талбай болон ойр орчмын газарт ямар нэг түүх, соёлын дурсгалт зүйл, археологийн олдвор илрээгүй, цаашдын үйл ажиллагааны явцад олдох буюу илрэх аваас холбогдох хууль тогтоомжиын дагуу засаг захиргааны анхдагч нэгж болон ШУА-ын харъяалах

байгууллагуудад нэн даруй мэдэгдэнэ /төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно/.

### 2.1.9 Осол, эрсдэлийн төлөвлөгөө ба ХАБЭА-н чиглэлээр гүйцэтгэсэн ажлууд

Үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагаанд гүйцэтгэх захирлын баталсан “Дотоод аудит, дотоод хяналт хэрэгжүүлэх журам”-ыг баримтлахаас гадна ХАБЭА-н чиглэлийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээг “Төгс баян хүрээ” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу авч ажиллаж байна (Гэрээг хавсаргав).

Үйлдвэрийн байр нь MNS 5023:2001 “Мах, махан бүтээгдэхүүн. Эрүүл ахуйн аюулгүй байдлын үндсэн шаардлага” стандартын дагуу үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг ба хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, бусад тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон.

Агааржуулалтын системтэй, бүтээгдэхүүнийг өрөөнд ил тавьж хөргөхгүй байх зорилгоор хөргүүрийн иж бүрэн автомат тоног төхөөрөмж суурилуулсан нь цаг хугацааг хэмнэхээс гадна өрөөний температур, чийгшилд нөлөө үзүүлэхгүй, бүтээгдэхүүн гадны зүйлсээр бохирдохоос сэргийлсэн алхам болно. Чанасан махыг сагсанд хийгээд хөргөх төхөөрөмжинд хийж 30-н минут болоход гүний температур нь шууд савлагаа хийх хэмжээнд хүрдэг. Энэ тоног төхөөрөмж нь бүтээгдэхүүний гүний температурыг тохируулсан утга хүртэл хөргөх хамгийн орчин үеийн хөргөлтийн төхөөрөмж болно.

Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл нь тавигдах шаардлага болон хэрэглээний зориулалтаас хамаарч, цех тасгаараа өөр өөр өнгө, хийцлэлтэй байдаг онцлогтой ба жилд 3 сая гаруй төгрөг зарцуулдаг.












Эрсдлийн буюу галын аюулаас сэргийлэх үүднээс галын хорыг өрөө болон кридорт байрлуулсан ба иж бүрэн багаж хэрэгсэл бүхий галын сарайг гадна талбайд байршуулж, галын дүгнэлтийг авч ажиллалаа.












Ажлын байрны ариутгал, халдваргүйтгэлийг нийслэлийн мал эмнэлгийн газартай байгуулсан гэрээний дагуу жилд 2 удаа хийлгэдэг (Гэрээг хавсаргав).

### 2.1.10 Удирдлага зохион байгуулалт, оролцогч талуудад тайлагнах чиглэлээр

Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаснаар, байгаль орчны аудит болон газрын төлөв байдал чанарын хянан баталгааны тайланг 2024 онд хийлгэхээр тусгасан ч 2023-2024 онд үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотойгоор хийгдээгүй, ирэх 2025 оноос үйл ажиллагаа эхлэхээр хийлгэхээр тогтсон.

Дүүрэг болон хорооны зүгээс ямар нэг хамтран ажиллах санал, хүсэлт ирээгүй /үйл ажиллагаа явуулаагүй тул/ ба ХАБЭА-ын зөвлөх үйлчилгээ авах гэрээний хүрээнд хог хаягдлын сургалт зохион байгуулахаар тохиролцсон (үйлдвэр түр зогсолттой байгаа).

Холбогдох журамд заасны дагуу 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг ийнхүү боловсруулан илгээж байгаа ба үх дүнг БГД-ийн ЗДТГ, ИНХ болон 20-р хороонд 12 сард багтаан хүргүүлнэ.

## 2.1.11 Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөө ба хэрэгжилт

*Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахарга хэмжээ | Тоо хэмжээ | Зардал, төгрөг | | Хугацаа | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Гүйцэтгэл ( %) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөсөн | Зарцуулсан | | | |
| | | | 1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | | | | | |
| 1.1 | Үйлдвэрт ажиллах бага оврын хөргүүрийн машин механизмаас ялгарах утаа, үйлдвэрийн технологийн процессоос гарах хаягдал, чимээ шуугиан нь үйлдвэрийн ажлынбайранд нөлөөлөх,агаарт бохирдол үүсэх | Авто тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, агаарын бохирдлын төлбөрийг төлөх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх | | Дотоод зардлаар | | Үйл ажиллагааны туршид | Улсын автотээврийн үзлэгт компаний 4 машин оруулж "Тэнцсэн" үнэлгээ авсан ба агаарын бохирдлын төлбөрийг бүрэн барагдуулсан. Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайн үед нь хийж ирсэн. | 100 |
| | | Тээврийн хэрэгслийн яндand шүүлтүүр тавих | 6 ш | 731,400 | 731,400 | 2024 он | Авто тээврийн улсын үзлэгээр оруулахын өмнө бүх машины яндангийн шүүлтүүрүүдийг сольсон. | 100 |
| | | Чимээ ихтэй тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ, шинэчлэл хийх арга хэмжээ авах | | Дотоод зардлаар | | Үйл ажиллагааны туршид | Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг грацикийн дагуу тогтмол хийж ирсэн ба дуу чимээ ихтэй төхөөрөмж ашигладаггүй /бүх төхөөрөмж цахилгаан/. | 100 |
| | | | 2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | | | | | |
| | Усны нөөцийг зөвшөөрөлгүй ашиглах, их хэмжээгээр хэтрүүлэн ашигласнаас гүний усны нөөцөд нөлөөлөх | Ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар жил бүр гаргуулж, ус ашиглах эрх авах | | Дотоод зардлаар | | 2024 | Нийслэлийн БОГ-ын 2024-05-02 өдрийн 2024/40 тоот ус ашиглуулах дүгнэлттэй. | 100 |
| | | Ус ашиглах гэрээг харьяа газрын байгаль орчны байцаагчтай байгуулах | | Дотоод зардлаар | | 2024 | БГД-ийн ЗД-ын 2022-04-19 өдрийн 46 тоот ус ашиглах гэрээг байгуулж ажилласан. | 100 |
| | Усны нөөц, чанарт нөлөөлөх | Усны эх үүсвэрийг бохирдохоос хамгаалжэрүүл | 1 | 50,000 | 50,000 | 2024 он | Гүний худаг узель дотор байдаг тул гаднаас бохирдох нөхцөл үгүй ч бүх | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ахуйн бүс тогтоох, гүний худгийг хамгаалах, тэмдэгжүүлэх | | | | | шугамыг өнгөөр ялгаж, хориглолтын бүс тогтоон тэмдэгжүүлсэн. | |
| | Үйлдвэрийн хаягдал болон ахуйн бохир усны шугам сүлжээнд эвдрэл гарснаар хөрс бохирдох зэргээр гадаргын болон бага гүний усны нөөцийг бохирдуулах | Технологийн горимыг чанд даган мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах | | Дотоод зардлаар | | 2024 | Үйлдвэрлэлийн технологийн горимыг чанд мөрдөж, засвар үйлчилгээг тогтмол хийж ирснээр ямар нэг гэмтэл, доголдол гараагүй. Болзошгүй аюулын үед ашиглах багаж, хэрэгсэл /хязгаарлах, соруулах, шингээх материал, сангийн багаж хэрэгсэл/-ийг үйлдвэрлэлийн талбайд бэлэн байлгадаг. | 100 |
| 3. Хөрсөн бүрхэвч, газрын гадаргат үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | | | | | | | | |
| | Хог хаягдлыг зориулалтын бус талбайд, ил задгай хадгалах нь агаар, хөрс бохирдох | Эвдрэлд өртсөн талбайг тогтмол сэргээж янзлах, хатуу хог хаягдлыг тогтмол хугацаанд тээвэрлэн зайлуулах, ариутгал хийх | | Дотоод зардлаар | | 2024 | Үйлдвэрийн гадна орчны талбайн 98%-г бүхэлд нь цардаж, бетондсон. Ус тогтдоггүй, хог хаягдал болон бусад төрлийн бохирдолгүй, цэвэр цэмцгэр орчинг бүрдүүлдэг. | 100 |
| | Шатах, тослох материал, хөрсөнд нэвчиж, ахуйн хог хаягдлаар хөрс бохирдох | Технологийн горимыг чанд даган мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг үйлдвэрийн талбайд бэлэн байлгах | | Дотоод зардлаар | | 2024 | Технологийн горимыг чанд мөрдөж, засвар үйлчилгээг тогтмол хийдэг. Болзошгүй аюулын үед ашиглах багаж, хэрэгсэл /хязгаарлах, соруулах, шингээх материал/-ийг үйлдвэрлэлийн талбайд бэлэн байлгадаг. | 100 |
| | | Асгаралтаас урьдчилан сэргийлэх, дотоод журам боловсруулж, асгаралт гарсан тохиолдолд иж бүрдлийг хэрхэн ашиглах талаар сургалтыг тогтмол явуулах | | Дотоод зардлаар | | 2024 | “Дотоод аудит, дотоод хяналт” нэртэй үйлдвэрийн дотоод журамтай, шатах тослох материалын асгаралт гарах эрсдэл үгүй /бүх автомашинууд авто засварын газраар үзүүлж, үйлчилгээ авдаг тул/ | 100 |
| 4. Нөхөн сэргээлт, тохижилтын чиглэлээр | | | | | | | | |
| | “Тэрбум мод” хөтөлбөрийн | Биологийн нөхөн сэргээлт – хайлаас мод тарих | 10ш | 150,000 | 150,000 | 2024 | Чонын элэг жимсний модыг 10ш тарьсан, арчилгааг тогтмол хийдэг. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүрээнд төслийн талбайд тарималжуулах | Байгууллагын эзэмшлийн болон өмчлөлийн газарт зохих журмын дагуу бут, сөөг тарьж, зүлэгжүүлэх | 150м$^2$ | 1,500,000 | - | 2024 | Үйлдвэрийн гадна мод тарих боломжгүй тул ирэх жил болтол хйошлуулсан /Хашааны гадна хэсэг усны шугам хоолой тавих ажлын улмаас ухагдаж, ажиллах боломжгүй болсон/. | 0 |
| ***Нийт*** | | | | ***1,650,000*** | ***150,000*** | ***Үлдэгдэл: 1,500,000*** | | |
| 5. Түүх, соёлын өвийг хамгаалах чиглэлээр | | | | | | | | |
| | Түүх, соёлын өвийг хамгаалах | Түүх, соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх | | Дотоод зардлаар | | Үйл ажиллагааны туршид | Эзэмшил болон орчны газарт дусргалт зүйл үгүй. | 100 |
| 6. Осол, эрсдэлийн менежментийн чиглэлээр | | | | | | | | |
| | Гал түймрийн улмаас үйлдвэрийн үйл ажиллагаа доголдох, зогсох | Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах | | Дотоод зардлаар | | 2024 | Галын хорыг 25-30м2 тутамд байхаар тооцоолж, ... галын хор байршуулсан ба галын сарайг үйлдвэрийн хашаанд иж бүрэн тоног хэрэгсэлтэйгээр байрлуулсан. | 100 |
| | Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюулүүсэх | Техник, тоног төхөөрөмж болон технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах | | Дотоод зардлаар | | 2024 | Үйлдвэрийн тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгсэл, цахилгаан, дулаан, сантехникийн шщгамын засвар үйлчилгээг тогтмол хийж, хяналт тавьж ирсэн. Гэмтэл, доголдол гараагүй. | 100 |
| | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дэглэм | Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах хэрэгслээр хангах | 35 ажилтан | Дотоод зардлаар | | 2024 | Ажилтан нэг бүрийг ХХ-ийн иж бүрэн хувцсаар хангадаг. Жилд 3сая гаруй төгрөгийн зардал гардаг. | 100 |
| | | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах | | Дотоод зардлаар | | 2024 | ХАБЭА-ын сургалт болон зөвлөх үйлчилгээг "Төгс баян хүрээ" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 11 сард зохион байгуулна. Одоогоор үйлдвэр зогсолтын горимд байгаа. | 100 |
| | | Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг | | Дотоод зардлаар | | 2024 | Баянгол дүүргийн 7-р төвтэй | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | алдагдсанаар осол аваар гарах | шинжилгээнд хамруулах төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх | | | | | хамтран ажиллах гэрээний дагуу үзлэгт 12 хүн хамруулсан /одоогоор 12 ажилтантай байгаа/. | |
| | | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих | | Дотоод зардлаар | | 2024 | "Дотоод аудит, дотоод хяналт" нэртэй үйлдвэрийн дотоод журмыг хэрэгжүүлэн ажилладаг. | 100 |
| 7. Хог хаягдлын менежментийн чиглэлээр | | | | | | | | |
| | Ахуйн | Ангилан хаях зориулалттай хогийн савыг үйлдвэрт байрлуулах | 5ш | 250,000 | 250,000 | 2024 | Хог хаягдлын ангилан ялгах зориулалтын зөөврийн 5ш савыг авч, үйлдвэрийн дотор 3ш, гадна талд 2ш-ийг тус тус тавьж, ашиглаж байна. . | 100 |
| | | Хог хягдлыг зориулалтын цэгт хаях, дүүргийн хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлэх | | 27,456 | 27,456 | 2024 | Ахуйн хог хаягдлыг үйлдвэрийн нэгдсэн хогийн цэгт цуглуулж, нийслэлийн "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-тай 2024-03-04 өдөр байгуулсан 24/22 тоот гэрээний дагуу тээвэрлүүлдэг. | 100 |
